



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 18

Мандалговь

Г Т.Уранбайгалийг албан тушаалд нэр Г  
дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Төмөрчөдөрийн Уранбайгаль 84.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Уранбайгалийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН

30021041



**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн даргын  
албан тушаалд нэр дэвшүүлсэн Төмөрчөдөрийн Уранбайгалийн тухай дүгнэлт**

1. Т.Уранбайгаль нь 1981 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвд төрсөн. 39 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Сутай дээд сургуулийг 2000-2004 онд Хууль зүй судлал мэргэжлээр, бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Ажлын туршлага: 2007-2008 онд Мандалговь хүнс ХХК-д худалдагч, 2008 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажилтан, 2009-2012 онд Дэрэн сумын ЗДТГ-т нийгмийн бодлого, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, 2012 оноос аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн хууль тогтоомж системчлэл, лавлагаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна.
4. Т.Уранбайгалийн төрийн захиргааны албанд ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ**